

**УРГАМАЛ ХАМГААЛАЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН, БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 2019-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

Багануур дүүрэг

№	Гүйцэтгэх ажлууд	Төлөвлөсөн хугацаа	Биелэлт	Дүгнэлт	Гүйцэтгэл
1.	Тус байгууллагатай уулзалт танилцуулга зохион байгуулж, хамтын ажиллагааны чиглэлийг тогтоон гэрээ байгуулах	2019.03	2019.04.11-ний өдөр ШАУИС-ийн удирдлагатай Санамж бичиг байгуулж төлөвлөгөө баталсан.	Хамтын ажиллагааны төлөвлөгөөний 2, 3, 5 дахь заалтыг хойшлуулсан.	100%
2.	Эрдэм шинжилгээний байгууллага, тариаланчид, үйлдвэрлэгчид, иргэдийг хамруулсан “Эмийн ургамал, жимс, жимсгэнэ тариалах нь” сэдэвт сургалт, зөвлөгөөн, зохион байгуулахад оролцох	Жил бүрийн 3,4 сар	Багануурт биотехнологийг эрчимтэй хөгжүүлэх суурь бэлтгэлийг хангах, дүүргийг Эко-Хот болгон хөгжүүлэх санаачлагын хүрээнд “Эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг ХААИС, УХЭШХ, ШАУИС, Монхимо ХХК-тай хамтран дүүрэгтээ 2019.06.21-ны өдөр зохион байгуулж, 40 гаруй хүн оролцож, 8 илтгэлийг тавьж, хэлэлцүүлэн санал зөвлөмжүүдийг өгөв. Тус зөвлөгөөнд тавигдсан илтгэлүүдийн сэдвийн жагсаалтыг хавсаргав.	Тус арга хэмжээг 2020 онд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан ч цар тахалтай холбоотойгоор тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.	100%
3.	Ховор ургамлыг тариалах чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, тариаланчид, үйлдвэрлэгчид, иргэдийн оролцоотой нээлттэй өдөрлөгийг зохион байгуулахад оролцох	Жил бүрийн 6,7 сар	2020 онд хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор цуцалсан.	Цаашид сургалт, нээлттэй өдөрлөг зэрэг арга хэмжээг цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөж зохион байгуулна.	-
4.	Плантацид тариалахад тохиромжтой ховор эмийн ургамлуудын судалгаа явуулж, гербари цуглуулга хийхэд дэмжлэг үзүүлэх	2019-2020	- 2019 онд УХЭШХ-ээс нэг ургамлын гербари бэлэглэсэн нь манай цуглуулгын эхлэл болсон. - 2020 онд Паркийн хувьд плантацид тариалахад тохиромжтой ховор эмийн ургамлуудын гербари цуглуулга хийхэд талаар эрдэмтэн судлаачдаас зөвлөгөө авсан.	Цаашид парк гербари цуглуулга хийх ажлыг эрчимжүүлж, баяжуулах зорилготой ажиллана.	70%
5.	Байгууллагуудын хамтарсан “Бүтээлч-Аялал” зохион байгуулах	2019 оны 5, 6 сар	- 2019.06.21-22-ны өдрүүдэд зөвлөгөөнд оролцсон эрдэмтэн, судлаачидтай хамтран Хэрлэнбаян-Улаан болон Хөх нуурын	- УХЭШХ-ийн зүгээс ШАУИС, ХААИС-ийн багш судлаачид өөрийн плантацийн үйл	100%

<p>Үүнд:</p> <p>→ Дарханы эрдэм шинжилгээний хүрээлэн</p> <p>→ Хэрлэнбаян-Улаан болон Хөх нуурын биостанцын ховор ургамлын тариалан</p>		<p>биостанцын ховор ургамлын плантацитай танилцаж, туршлага судлаж, 18 хүн оролцсон бүтээлч аялалыг зохион байгуулав.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Плантаци байгуулсан газар орон, цаг уур, хөрсний байдлыг үзэж, плантацийн ерөнхий зохион байгуулалттай танилцав.</li> <li>- 2020 онд тус хүрээлэнгээс Борнуурын плантаци үзүүлэх байсан боловч цар тахалын хол хорионы улмаас хойшлуулсан.</li> </ul>	<p>ажиллагаатай танилцуулсан маш үр дүнтэй, туршлага хуримтлуулсан бүтээлч аялал болсон гэж дүгнэсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэрлэнбаян-Улааны плантацийн газар орон нь Баганууртай ижил төстэй байгаа нь паркад плантаци байгуулахад боломжтой гэж үзсэн.</li> <li>- Цаашид сургалт, нээлттэй өдөрлөг зэрэг арга хэмжээг цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөж зохион байгуулна.</li> </ul>	
<b>Хэрэгжилтэд тооцох боломжгүй арга хэмжээний тоо</b>				<b>3</b>
<b>Хэрэгжилтийн дундаж хувь</b>				<b>92,5%</b>

ХЯНАСАН:  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*B. Mönkhuyag*

Б.МӨНГӨНХУЯГ

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
КЛАСТЕР ИНЖЕНЕР

*E. Enkhzaya*

Э. ЭНХЗАЯА